



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- |      |  |           |      |
|------|--|-----------|------|
| 250. | Үндсэн хуулийн цэцийн гишүүдийг<br>томилох тухай   | Дугаар 30 | 1102 |
| 251. | Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс<br>чөлөөлөх тухай  | Дугаар 31 | 1102 |
| 252. | Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээс<br>чөлөөлөх, гишүүнээр томилох тухай  | Дугаар 32 | 1103 |
| 253. | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн<br>Хурлын ээлжит сонгуулийн зардлын<br>хэмжээг батлах тухай  | Дугаар 33 | 1104 |
| 254. | “Хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт,<br>түүнийг бүртгэх, хадгалах журам батлах тухай”<br>Улсын Их Хурлын 2007 оны 9 дүгээр тогтоолыг<br>хүчингүй болсонд тооцох тухай | Дугаар 34 | 1104 |

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- |      |  |           |      |
|------|--|-----------|------|
| 255. | Элчин сайдыг эгүүлэн татах,<br>томилох тухай | Дугаар 82 | 1105 |
| 256. | Элчин сайдыг эгүүлэн татах,<br>томилох тухай | Дугаар 83 | 1105 |

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- |      |   |           |      |
|------|---|-----------|------|
| 257. | Автобензин, дизелийн түлш, мах, нийтийн<br>тээврийн үнийг тогтворжуулах зарим<br>арга хэмжээний тухай | Дугаар 53 | 1106 |
| 258. | Тогтоолд өөрчлөлт оруулах тухай   | Дугаар 54 | 1108 |
| 259. | Үнэт цаас болон Засгийн газрын<br>баталгаа гаргах тухай   | Дугаар 55 | 1108 |
| 260. | Үндэсний хөтөлбөр батлах тухай  | Дугаар 56 | 1109 |



**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН  
ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

261. | Эрүүгийн хуулийн 294 дүгээр зүйлийн зарим  
заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг  
зөрчсөн эсэх тухай маргааныг хянан  
шийдвэрлэсэн тухай | Дугаар 03 | 1116

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2012 оны 05 дугаар | | Улаанбаатар  
сарын 09-ний өдөр | Дугаар 30 | хот

**Үндсэн хуулийн цэцийн гишүүдийг  
томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын санал болгосноор Дуламын Сугарыг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болгосноор Тогоочийн Лхагвааг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр тус тус томилсугай.

2.Энэ тогтоолыг 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2012 оны 05 дугаар | | Улаанбаатар  
сарын 09-ний өдөр | Дугаар 31 | хот

**Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс  
чөлөөлөх тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 4 дүгээр



зүйлийн 2, 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон тул Жигжидийн Болдбаатарыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 05 дугаар  
сарын 09-ний өдөр

Дугаар 32

Улаанбаатар  
хот

### **Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээс чөлөөлөх, гишүүнээр томилох тухай**

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2, 4.5 дахь хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр Бямбажавын Ганбат, Ганбаатарын Гэрэлт-Од, Баянмөнхийн Билэгт, Дашзэвэгийн Эрдэнэчулуун, Нацагийн Дагва нарыг тус тус томилсугай.

2.Бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон тул Пандийн Бямбацэрэн, Хандсүрэнгийн Пүрэвсүрэн, Мондооны Мэндбилэг, Данзангийн Сандаг-Очир нарыг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээс тус тус чөлөөлсүгэй.

3.Энэ тогтоолыг 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 05 дугаар  
сарын 09-ний өдөр

Дугаар 33

Улаанбаатар  
хот

### **Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай**

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.6 дахь хэсэг, Сонгуулийн ерөнхий хорооны саналыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2012 оны ээлжит сонгуулийн улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын хэмжээг 464.9 сая төгрөгөөр тогтоосугай.

2.Энэ тогтоолын 1-д заасан зардлыг улсын төсвөөс гаргахыг Монгол Улсын Засгийн газар /С.Батболд/-т даалгасугай.

3.Энэ тогтоолыг 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 05 дугаар  
сарын 09-ний өдөр

Дугаар 34

Улаанбаатар  
хот

### **“Хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хадгалах журам батлах тухай” Улсын Их Хурлын 2007 оны 9 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцох тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.”Хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хадгалах журам батлах тухай” Улсын Их Хурлын 2007 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 9 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

2.Энэ тогтоолыг 2012 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 05 дугаар  
сарын 02-ны өдөр

Дугаар 82

Улаанбаатар  
хот

### Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Австралийн Холбооны Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Цэрэндорж овогтой Жамбалдоржийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Австралийн Холбооны Улсад суух Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайдаар Равдангийн Болдыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 05 дугаар  
сарын 02-ны өдөр

Дугаар 83

Улаанбаатар  
хот

### Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Арабын Бүгд Найрамдах Египет Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Дашдоржийн Баярхүүг эгүүлэн татаж, Монгол Улсаас Арабын Бүгд Найрамдах Египет Улсад суух Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайдаар Банзрагчийн Одонжилийг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**2012 оны 2 дугаар  
сарын 15-ны өдөр

Дугаар 53

Улаанбаатар  
хот**Автобензин, дизелийн түлш, мах, нийтийн  
тээврийн үнийг тогтворжуулах зарим  
арга хэмжээний тухай**

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Хүнсний тухай хуулийн 7.3, Өрсөлдөөний тухай хуулийн 13.4, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 56.1, Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.4.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Автобензин, дизелийн түлшний үнэ өссөнтэй холбогдуулан нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлж байгаа их, дунд, бага оврын автобус бүхий аж ахуйн нэгж, байгууллагын шатахууны үнийн зөрүүнээс үүссэн алдагдлыг 2012 оны 1 дүгээр сарын гүйцэтгэлээр тооцон нийт 395,953.500 (гурван зуун ерэн таван сая есөн зуун тавин гурван мянга таван зуун) төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас гаргаж, Нийслэлийн Засаг даргад олгохыг Сангийн сайд Д.Хаянхярваад зөвшөөрсүгэй.

2. Шатахууны үнийн зөрүүнээс үүссэн алдагдлыг төсвөөс олгож байгаатай холбогдуулан нийтийн тээврийн үйлчилгээний үнэ тарифыг нэмэгдүүлэхгүй байх зохицуулалт хийж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга Г.Мөнхбаярт, нийтийн тээврийн байгууллагын дизелийн түлшний хангалт, нийлүүлэлтийг жигд, үнийг тогтвортой байлгах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллахыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт нарт тус тус даалгасугай.

3. Автобензин, дизелийн түлшний нөөц бүрдүүлэх, үнийн огцом өсөлтөөс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай хөрөнгийн тооцоо, судалгаа хийж, хянасны үндсэн дээр Засгийн газарт оруулан шийдвэрлүүлж байхыг Сангийн сайд Д.Хаянхярваа, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт нарт даалгасугай.

4. Нийслэлийн хүн амын хэрэгцээнд зориулан мах бэлтгэн 2012 оны 3 дугаар сарын 1-нээс 7 дугаар сарын 1-ний хооронд нийлүүлэх хэмжээг хавсралт ёсоор баталж, уг ажлыг аймгийн Засаг дарга нартай хамтран зохион байгуулахыг Нийслэлийн Засаг дарга Г.Мөнхбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай нарт даалгасугай.

5. Махны улирлын нөөцийг бүрдүүлэхэд шаардлагатай 40.0 (дөчин) тэрбум төгрөгийг нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчид төсвийн



зээл хэлбэрээр олгон санхүүжүүлэхийг Сангийн сайд Д.Хаянхярваад зөвшөөрсүгэй.

6. Нийслэлийн хүн амын хэрэгцээнд зориулан 2012 оны хавар, зуны улиралд нөөцийн мах нийлүүлэх гэрээг аймгийн Засаг дарга нар болон аж ахуйн нэгжтэй байгуулж, оновчтой хэлбэрээр борлуулан, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллахыг нийслэлийн Засаг дарга Г.Мөнхбаярт үүрэг болгосугай.

7. Малчдад шаардлагатай тоног төхөөрөмж, бүтээгдэхүүнийг хөнгөлөлттэй нөхцөлөөр мал, махаар арилжаалах ажил зохион байгуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунайд даалгасугай.

8. Гахай, шувууны мах, загас, загасан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импортыг нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, нийслэлийн Засаг дарга Г.Мөнхбаяр нарт үүрэг болгосугай.

9. Дотоодын зах зээлийг хамгаалах, махны хангамжийг тогтворжуулах зорилгоор махны экспортыг 2012 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүртэл түр хугацаагаар хязгаарлахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Р.Содхүүд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**САНГИЙН САЙД**

**Д.ХАЯНХЯРВАА**

Засгийн газрын 2012 оны 53 дугаар  
тогтоолын хавсралт

**НИЙСЛЭЛИЙН ХҮН АМЫН ХЭРЭГЦЭЭНД ЗОРИУЛАН МАХ  
БЭЛТГЭН 2012 ОНЫ 3 ДУГААР САРЫН 1-НЭЭС 7 ДУГААР  
САРЫН 1-НИЙ ХООРОНД НИЙЛҮҮЛЭХ ХЭМЖЭЭ**

№	Аймаг	Бэлтгэх махны хэмжээ, тонн	Өдөрт нийлүүлэх махны хэмжээ, тонн
1	Дорнод	715	6
2	Сүхбаатар	870	7
3	Хэнтий	1035	8
4	Хөвсгөл	1400	11
5	Архангай	1300	10
6	Булган	1020	8
7	Увс	740	6
8	Баян-Өлгий	420	4



9	Ховд	710	6
10	Завхан	915	8
11	Говь-Алтай	775	6
12	Баянхонгор	1020	8
13	Өвөрхангай	1080	9
14	Төв	970	8
15	Дундговь	550	5
16	Дорноговь	540	5
17	Сэлэнгэ	540	5
18	Өмнөговь	400	3
	Дүн	15000	125

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 2 дугаар  
сарын 20-ны өдөр

Дугаар 54

Улаанбаатар  
хот

### Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

“Иргэдийг орон сууцжуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2011 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 138 дугаар тогтоолын 2 дугаар зүйлд “50 м<sup>2</sup>” гэснийг “55 м<sup>2</sup>” гэж өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**ЗАМ, ТЭЭВЭР, БАРИЛГА, ХОТ  
БАЙГУУЛАЛТЫН САЙД**

**Ц.ДАШДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 2 дугаар  
сарын 20-ны өдөр

Дугаар 55

Улаанбаатар  
хот

### Үнэт цаас болон Засгийн газрын баталгаа гаргах тухай

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 7.1.4, 14.1, 16.2, 22.1.4, Монгол Улсын Нэгдсэн төсвийн тухай хуулийн 6.3, Улсын Их Хурлын 2011 оны 14 дүгээр тогтоол, Улсын Их Хурлын 2011 оны 15 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Иргэдийг жилийн 6 хүртэл хувийн хүүтэй орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамруулахад шаардагдах санхүүгийн эх үүсвэр



бүрдүүлэх зорилгоор 200.0 (хоёр зуун) тэрбум хүртэлх төгрөгийн үнэт цаас гаргахыг Монгол Улсын Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Батжаргал)-д зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрт Засгийн газрын баталгаа гаргахыг Сангийн сайд Д.Хаянхярваад зөвшөөрсүгэй.

3. Монгол Улсын Хөгжлийн банкны 200.0 (хоёр зуун) тэрбум хүртэлх төгрөгийн үнэт цаасны эх үүсвэр бүрдэх хүртэл хугацаанд арилжааны банкны өөрийн эх үүсвэрийг ашиглан иргэдэд орон сууцны хөнгөлөлттэй зээл олгох үйл ажиллагааг арилжааны банктай хамтран Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам, Сангийн яам, Нийслэлийн Засаг дарга нарын хамтарсан шийдвэрээр баталсан журмын дагуу зохион байгуулахыг Монгол Улсын Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Батжаргал)-д даалгаж Монголбанкны ерөнхийлөгч Л.Пүрэвдоржид зөвлөсүгэй.

4. Орон сууцны хөнгөлөлттэй зээлд зориулан гаргасан Монгол Улсын Хөгжлийн банкны үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөр, иргэдэд олгох хөнгөлөлттэй зээлийн хүү болон арилжааны банкаар дамжуулан олгосон орон сууцны зээлийн хүүгийн зөрүүг Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуульд тусган хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Д.Хаянхярваад даалгасугай.

5. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд М.Энхболдод даалгаж, Монголбанкны ерөнхийлөгч Л.Пүрэвдоржид зөвлөсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**САНГИЙН САЙД**

**Д.ХАЯНХЯРВАА**

## **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2012 оны 2 дугаар  
сарын 20-ны өдөр

Дугаар 56

Улаанбаатар  
хот

### **Үндэсний хөтөлбөр батлах тухай**

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлалын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:



1.“Монгол судлалыг хөгжүүлэх Үндэсний хөтөлбөр”-ийг хавсралт ёсоор баталсугай.

2.“Монгол судлалыг хөгжүүлэх Үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Боловсрол соёл, шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаярт даалгасугай.

3. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 2012 онд шаардагдах зардлыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын төсвийн багцад багтаан санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаяр, цаашид шаардагдах хөрөнгийг жил бүр улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг Сангийн сайд Д.Хаянхярваа нарт тус тус даалгасугай.

4. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг 2 жил тутам Засгийн газарт танилцуулж байхыг Боловсрол соёл, шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаярт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААНЫ САЙД**

**Ё.ОТГОНБАЯР**

Засгийн газрын 2012 оны 56 дугаар  
тогтоолын хавсралт

**МОНГОЛ СУДЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ  
ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР**

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улс олон мянган жилийн түүхтэй монгол угсаатны гал голомт, өлгий нутаг, монгол үндэстнээс бүрдсэн тусгаар тогтносон улс гэдэг утгаараа монгол судлалын олон салбарыг эрчимтэй хөгжүүлэх өргөн боломжтой юм. Ийм ч учраас Монгол Улс олон улсын монгол судлалын төв байх ёстой гэсэн үзэл баримтлал бүрэлдэн тогтож, гадаадын монголч эрдэмтэд хүлээн зөвшөөрдөг боллоо. 1970-1990 оны үед тэр үеийн социалист орнууд төдийгүй Япон, Англи, Франц, Энэтхэг зэрэг бусад орны олон оюутан Монгол Улсад суралцан төгссөн бөгөөд тэдгээрийн олонхи нь өөр өөрийн орны монгол судлалын салбарыг манлайлж байна.

Монгол судлалын чиглэлээрх олон улсын хандлага сүүлийн 10 жилийн хугацаанд нэлээд өөрчлөгдөн гадаад орнууд дахь монгол судлалын эрч хүч буурч, Америк, ХБНГУ, Англи, ОХУ, Унгар, Япон, Болгар зэрэг орны 15 их сургууль, эрдэм шинжилгээний төвүүдийн дэргэдэх



монгол судлалын үйл ажиллагаа хаагдсан байна. Түүнчлэн Дорно дахины судлалын томоохон сэтгүүлүүдэд монголын холбогдолтой өгүүлэл, баримт материал гарах нь хязгаарлагдмал болжээ. Сүүлийн 5 жилийн байдлаар ернөдийн орнуудаас манай их, дээд сургуулиудад монгол судлалын чиглэлээр суралцаж байгаа оюутны тоо цөөрч байна.

Иймээс даяаршиж буй өнөөгийн нөхцөлд монгол судлалын асуудлыг төр ивээлдээ авч бодлогоор дэмжих, монголын түүх, соёл, хэл, зан заншил, үндэсний баялаг өв сангаа судлах, хамгаалах, хойч үедээ өвлүүлэн үлдээх, монгол судлалыг дотоод, гадаадад тогтвортой хөгжүүлэх үндэсний хэмжээний бүтэц бий болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Энэхүү шаардлагыг хангаснаар “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”, “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал” болон “Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал”-д тусгагдсан зорилтууд хэрэгжиж Монгол Улс олон улсын монгол судлалын цөм байх байр суурийг хадгалан үлдэх нөхцөл бүрдэх юм.

Хөтөлбөрийг 2012-2016 онд хэрэгжүүлэх бөгөөд үйл ажиллагааны санхүүжилтийг улсын төсөв, гадаад орон, олон улсын байгууллага, бизнесийн байгууллагын хандив тусламж, төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөс бүрдүүлэн шийдвэрлэх болно.

Хөтөлбөр хэрэгжсэнээр нэгдүгээрт Монгол Улс олон улсын монгол судлалын төв байх бодит боломж нэмэгдэнэ, хоёрдугаарт үндэсний хэл, соёлын дархлаа бэхжиж, манай улсын гадаад нэр хүнд олон улсын хэмжээнд өснө.

#### Хоёр. Үндэсний хөтөлбөрийн зорилго

Монгол судлалыг хөгжүүлэх нэгдсэн бодлого, удирдлага, санхүүжилтийн тогтолцоо бий болгох, монгол судлалын үйл ажиллагаанд төр-шинжлэх ухаан- бизнесийн идэвх, оролцоог нэмэгдүүлэх, монгол судлаачдын залуу халааг бэлтгэх, мэргэшүүлэх, монгол судлалыг дотоод, гадаадад гүнзгийрүүлэн хөгжүүлэх, хөхиүлэн дэмжих орчин бүрдүүлэхэд оршино.

#### Гурав. Үндэсний хөтөлбөрийн зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд дараахь зорилтыг дэвшүүлж байна:



Зорилт 1. Монгол судлалыг хөгжүүлэх нэгдсэн бодлого, удирдлага, санхүүжилтийн тогтолцоог бий болгох

3.1.1. монгол судлалын хүний нөөц, сургалт-судалгааны ажлын өнөөгийн байдалд үнэлгээ өгч цаашдын зорилтыг тодорхойлох;

3.1.2. монгол судлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, холбогдох журам, дүрмийг боловсруулан хэрэгжүүлэх;

3.1.3. монгол судлалыг хөгжүүлэх үйл ажиллагаанд зохицуулалт хийж нэгдсэн удирдлагаар хангах Монгол судлалын Үндэсний зөвлөл (МСҮЗ) байгуулах;

3.1.4. монгол судлалын үйл ажиллагааны санхүүжилтийг улсын төсөвт тусган чиглэл бүрт нээлттэй, зохистой, жигд хуваарилах;

3.1.5. монгол судлалын мэдээллийн нэгдсэн сан байгуулж, цахим хэлбэрээр өргөжүүлэх, дэлхий дахинд таниулах.

Зорилт 2. Дотоод, гадаадын монгол судлаачдын залуу халааг бэлтгэх, чадавхийг хөгжүүлэх

3.2.1. дотоод, гадаадын залуу монгол судлаачийг Монгол Улсад магистрантур, докторантурт сурахад дэмжлэг үзүүлэх, тэтгэлэг олгох;

3.2.2. залуу монгол судлаачдын олон улсын зуны сургалт зохион байгуулах, судалгааны тэтгэлэг олгох;

3.2.3. судлаач, эрдэмтдийг харилцан солилцох хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх.

Зорилт 3. Монгол судлалыг дотоод, гадаадад гүнзгийрүүлэн хөгжүүлэх, хөхиүлэн дэмжих

3.3.1. гадаадын монгол судлаачдад Монгол Улсад суралцах, судалгаа хийхэд дэмжлэг үзүүлэх, тэтгэлэг олгох;

3.3.2. монгол судлалын олон улсын хурал, семинар, симпозиумыг дэмжих, санхүүжүүлэх.

3.3.3. гадаад дахь монгол судлалын төвийг дэмжих, сэргээх, шинээр үүсгэх чиглэлээр ажиллах, тус төвүүдэд ажиллаж байгаа монголын эрдэмтдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх;



3.3.4. монгол судлалын тэргүүлэх чиглэлээр дотоод, гадаадын монголч эрдэмтдийн суурь судалгааны хамтарсан төсөл, сэдэвт ажлыг хөхиүлэн дэмжих, санхүүжүүлэх;

3.3.5. гадаадын монголч эрдэмтдэд “Оны шилдэг бүтээл” шагнал хүртээх;

3.3.6. монголч эрдэмтдийн шилдэг бүтээлд Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит шагнал, Шинжлэх ухааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний нэрэмжит шагнал, Шинжлэх ухааны академийн шагнал олгох;

3.3.7. монгол судлаачдыг гадаад, дотоодод зочин судлаачаар ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, санхүүжүүлэх;

3.3.8. монгол судлалын тодорхой чиглэлээр (монгол хэл, түүх, соёл) олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах, хилийн чанадад таниулах, сурталчлах;

3.3.9. олон улсын монгол судлалын эрдэм шинжилгээний сэтгүүл, мэдээллийн цуврал гаргах;

3.3.10. дэлхийн монгол судлалын шилдэг бүтээлийг монгол хэлээр орчуулж, хэвлэх, түгээх;

3.3.11. гадаад орнуудын сурах бичгүүдэд Монголын түүхийн тухай бичсэн мэдээлэл цуглуулах, буруу ташаа гарсан мэдээллийг засч залруулахад чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

#### Зорилт 4. Монгол судлалыг хүртээмжтэй, чанартай, үр ашигтай хөгжүүлэх орчин бий болгох

3.4.1. монгол судлалын номын сан байгуулж, баримтын хөмрөг бүрдүүлэн дотоод, гадаадын монгол судлаачдад архив, номын сангийн материалтай танилцах, судлах, ажиллах боломж олгох:

3.4.1.1. монгол судлалын талаар төрөөс баримталж байгаа бодлого, зорилтыг олон нийтэд хүргэх, сурталчлах;

3.4.1.2. монгол судлалын талаар шинээр хэвлэгдэж байгаа зохиол бүтээл, цувралын талаархи мэдээллийг нэгтгэн орчуулах, түгээх;

3.4.1.3. монгол судлалын сургалтын хөтөлбөрүүд боловсруулж, цахим хуудсанд байрлуулах, гадаадын монгол судлалын төвүүдэд мэдээлэх.



3.4.2. дотоод, гадаадын эрдэмтэн, судлаачдад мэдээллийн санг ашиглах, материалтай танилцах боломж олгож, ажиллах нөхцөлөөр хангах;

3.4.3. монгол үндэстний гарал үүсэл, түүх соёлыг дэлхий дахинд сурталчлах, үнэн зөв мэдээлэл өгөх зорилгоор гадаад орны нэр хүндтэй томоохон музей, үзэсгэлэнгийн газруудад байгаа Монголын түүх, соёлын бие даасан тасаг, танхимыг үзмэрээр баяжуулахад туслалцаа, дэмжлэг үзүүлэх;

3.4.4. гадаад, дотоодод монгол үндэстний соёлын өвийн болон шинжлэх ухаан технологийн үзэсгэлэн гаргах.

#### Дөрөв. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим

Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараахь зарчмыг баримтална:

4.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг эрх зүй, нийгэм-эдийн засаг, шинжлэх ухаан технологийн бодлоготой уялдуулан зохицуулах.

4.2. Монгол судлалын үйл ажиллагаанд олон хувилбартай, уян хатан, нээлттэй бодлого баримтлах.

4.3. Монгол судлалыг хөгжүүлэх үйл ажиллагааны өрсөлдөөн, мэдээллийн чөлөөт байдлыг хангах.

4.4. Монгол судлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа дээд боловсрол, эрдэм шинжилгээний байгууллагын ажилд зарцуулах хөрөнгө, санхүүгийн нөөцийг зохистой хуваарилах.

4.5. Монгол судлалын сургалт, судалгааны байгууллагуудын хооронд үр бүтээлтэй хамтын ажиллагаа явуулах нөхцөл боломжийг бүрдүүлэх.

#### Тав. Үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа

5.1. Үндэсний хөтөлбөрийг 2012-2016 онд 4 жилийн хугацаатай хэрэгжүүлнэ.

#### Зургаа. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

6.1. Шинжлэх ухааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын дэргэд Монгол судлалын Үндэсний зөвлөл (цаашид “зөвлөл” гэх) ажиллана.



6.2. Зөвлөлийн дарга нь Шинжлэх ухааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна.

6.3. Зөвлөл нь төр-эрдэм шинжилгээ-бизнесийн байгууллагын төлөөлөл болон эрдэмтдээс бүрдсэн 10 хүртэлх гишүүнтэй байх бөгөөд ажлын албатай байж болно.

6.4. Зөвлөл нь дараахь дурьдсан асуудлыг хэлэлцэж зөвлөмж гаргана:

6.4.1. Монгол судлалын өнөөгийн түвшин, цаашдын чиг хандлага;

6.4.2. Үндэсний хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх ажлыг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон боловсрол, соёл, шинжлэх ухааны талаар төрөөс баримталж байгаа бодлогод нийцүүлэх асуудал;

6.4.3. монгол судлалын чиглэлийн үйл ажиллагаа явуулж байгаа гадаад, дотоодын дээд боловсрол, эрдэм шинжилгээний байгууллагын хамтын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, идэвхжүүлэх асуудал;

6.4.4. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан;

6.4.5. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардал, санхүүжилт, хуваарилалт;

6.4.6. монгол судлалын байгууллага, нэгжийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хөгжүүлэх асуудал, түүнд төрөөс үзүүлэх дэмжлэг.

Долоо. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт, хяналт-шинжилгээ

Монгол судлалын Үндэсний зөвлөл нь энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан ажлуудыг дараах шалгуурын дагуу дүгнэнэ:

7.1. Монгол судлалын үндэсний хэмжээний бүтэцтэй болж, хүний нөөцийн чадавхи нэмэгдсэн байдал.

7.2. Сургалтын хөтөлбөрүүд судлаачдын сонирхол, шаардлагад нийцсэн байдал.



7.3. Дотоод, гадаадын монгол судлаачдын тоо, чанарын өсөлт.

7.4. Эрдэм шинжилгээний ажилд хамтын бүтээлийн эзлэх хувь.

7.5. Монгол судлалыг хөгжүүлэхэд хувийн хэвшил болон мэргэжлийн байгууллагын сонирхол, оролцоог нэмэгдүүлсэн байдал.

7.6. Судалгаа, эрдэм шинжилгээний ажил, хамтарсан төслийн үр дүн, хэрэглээ болсон байдал, хүртээмж.

7.7. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг өмнөх жилүүдтэй харьцуулахад гарсан орчны өөрчлөлт, шинэчлэлт.

Найм. Үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагааны санхүүжилт

8.1. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлыг улсын төсөвт тусган санхүүжүүлнэ.

8.2. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны санхүүжилт дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

8.2.1. улсын төсөв;

8.2.2. олон улсын байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын хандив тусламж;

8.2.3. хөтөлбөр, төслийн хөрөнгө;

8.2.4. бусад эх үүсвэр.

## — МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2012 оны 05 дугаар  
сарын 09-ний өдөр

Дугаар 03

Улаанбаатар  
хот

**Эрүүгийн хуулийн 294 дүгээр зүйлийн зарим  
заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг  
зөрчсөн эсэх тухай маргааныг хянан  
шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны  
танхим 12.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг  
Үндсэн хуулийн цэцийн орлогч дарга Н.Жанцан даргалж, Үндсэн хуулийн



цэцийн гишүүн Ж.Болдбаатар, Д.Наранчимэг /илтгэгч/, Ц.Сарантуяа, Д.Мөнхгэрэл нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Н.Болортунгалагийг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн О.Алтангэрэлийн итгэмжлэгдсэн төлөөлөгч А.Бадрал, өмгөөлөгч З.Сүхбаатар болон Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Н.Ганбямба нар оролцов.

Хуралдаанаар Эрүүгийн хуулийн 294 дүгээр зүйлийн 294.1 дэх хэсэгт “Захирагч эрх мэдэл албан тушаалынхаа байдлыг урвуулсан, хэтрүүлсэн, албаны бүрэн эрхээ хэрэгжүүлээгүйгээс үлэмж хэмжээний хохирол учирсан бол гурваас дээш зургаан сарын хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”, мөн зүйлийн 294.2 дахь хэсэгт “Энэ хэргийн улмаас их буюу онц их хэмжээний хохирол, хүнд хор уршиг учирсан бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэж заасан нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг ...нийгмийн..., байдал, ...эрхэлсэн ажил, албан тушаал ...боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно...” гэж заасныг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

***Нэг. Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хорооны оршин суугч, иргэн О.Алтангэрэл Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан мэдээлэлдээ:***

“Монгол Улсын Эрүүгийн хуулийн 294 дүгээр зүйлийн 294.1-д “Захирагч эрх мэдэл албан тушаалынхаа байдлыг урвуулсан, хэтрүүлсэн, албаны бүрэн эрхээ хэрэгжүүлээгүйгээс үлэмж хэмжээний хохирол учирсан бол ... ял шийтгэнэ.”, мөн 294.2-т “Энэ хэргийн улмаас их буюу онц их хэмжээний хохирол, хүнд хор уршиг учирсан бол ... ял шийтгэнэ.” гэж заасан байдаг. Эрүүгийн хуулийн уг 294.1, 294.2 дахь заалтад захирагч албаны бүрэн эрхээ хэрэгжүүлээгүйгээс хохирол, хүнд хор уршиг учирсан бол гэмт хэрэгт тооцохоор заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан “Хүнийг ...нийгмийн байдал ... эрхэлсэн ажил, албан тушаал ...боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно.” гэж заасныг зөрчсөн гэж үзэж байна.

Төрийн албан хаагчид /улс төрийн болон захиргаа, үйлчилгээний албан хаагч/ албан тушаалын эрх мэдлээ хэтрүүлэх, урвуулах тохиолдолд гэмт хэрэгт тооцож ял шийтгэж эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр Эрүүгийн хуульд заасан байдаг. Тухайлбал, Монгол Улсын Эрүүгийн хуулийн 263



дугаар зүйлд “Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах”, 264 дүгээр зүйлд “Төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх” тохиолдолд гэмт хэрэгт тооцож шийтгэхээр заасан.

Гэтэл Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлын төлөө амь насаа үл хайрлан цэргийн албанд хоёргүй сэтгэлээр насаараа зүтгэж байгаа Цэргийн албан хаагчдыг Цэргийн албан хаагч гэсэн эрхэлсэн ажил, албан тушаалаар нь ялгаварлан Эрүүгийн хуулийн 294 дүгээр зүйлд эрх мэдлээ урвуулах, хэтрүүлэх гэмт үйлдлээс гадна “Захирагч албаны бүрэн эрхээ хэрэгжүүлээгүй” гэсэн үйлдлийг нэмж эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт заасан “Хүнийг ...нийгмийн байдал ...эрхэлсэн ажил, албан тушаал ...-аар нь ялгаварлан гадуурхаж үл болно.” гэж заасныг зөрчсөн хэрэг болно.

Төрийн захиргааны болон бусад албан хаагчийн үйлдсэн албан тушаалын гэмт хэргийн хувьд албан тушаалын байдлаа хэтрүүлэх, урвуулах үйлдлийн төлөө эрүүгийн хариуцлага хүлээдэг байхад цэргийн албан хаагч, захирагч нар эрх мэдлээ хэтрүүлэх, ашиглах үйлдлээс гадна албаны эрх мэдлээ хэрэгжүүлээгүйгээс хохирол, хүнд хор уршиг учирсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нь Монгол Улсын иргэн бүр эрхэлсэн ажил, албан тушаал үл харгалзан хуулийн өмнө эрх тэгш байна гэсэн агуулга харагдахгүй байгаа юм.

Мөн Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйлийн 263.1, 263.2 дахь хэсэгт төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, хэтрүүлэх тохиолдолд хүлээлгэх ял шийтгэл нь Эрүүгийн хуулийн 294 дүгээр зүйлд заасан гэмт хэрэг үйлдсэн цэргийн албан хаагчид хүлээлгэх ял шийтгэлээс хамаагүй хөнгөн байгаа нь цэргийн албан хаагчийг эрхэлж буй ажил албан тушаалаар нь ялгаварлаж, эрх тэгш хандаагүй гэж үзэж байна.

Иймд Монгол Улсын Эрүүгийн хуулийн 294 дүгээр зүйл нь бүхэлдээ Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь заалтыг зөрчсөн гэж үзэж байгаа тул Үндсэн хууль зөрчсөн тухай дүгнэлт гаргаж өгөхийг хүсье.” гэсэн байна.

***Хоёр. Монгол Улсын Их Хурлын даргын 2012 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн 51 дүгээр захирамжаар томилогдсон Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Н.Ганбямба Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:***

“Улсын Их Хурлаас 2002 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр баталсан Эрүүгийн хуулийн 294 дүгээр зүйлийн 294.1, 294.2 дахь хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол



Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.", мөн зүйлийн 2 дахь хэсгийн "Хүнийг ...нийгмийн байдал, ...эрхэлсэн ажил, албан тушаал ...боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно." гэсэн заалтыг тус тус зөрчсөн тухай иргэн О.Алтангэрэлийн Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан өргөдөлтэй танилцаад маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хувьд дараах тайлбарыг гаргаж байна:

Хэн ч хууль, шүүхийн өмнө бусдаас онцгой, давуу эрх эдлэх ёсгүй ба хэнийг ч үндэслэлгүйгээр хилсээр шийтгэж, ямар нэг хариуцлага хүлээлгэж болохгүйтэй адил хэн боловч хийсэн хэргийнхээ төлөө заавал хариуцлага хүлээх ёстой. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх" зарчмын үндэс юм. Өөрөөр хэлбэл, хүн бүр эрхэлсэн ажил, албан тушаалын байдал зэргээс үл хамааран адил, тэгш эрх эдэлж, үүрэг хүлээх, энэхүү эрхээ баталгаатай эдлэх боломжоор адилхан хангагдсан байхыг ойлгоно. Харин "Хүнийг ...нийгмийн байдал, ...эрхэлсэн ажил, албан тушаал, ...боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно." гэдэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлд заасан хүний үндсэн эрх буюу түгээмэл эрхийг тэгш, ялгаваргүйгээр эдлэхтэй холбоотой бөгөөд харин тухайн хүний албан тушаалтныхаа хувьд эдэлж байгаа тусгай эрхэд хамаарахгүй юм.

Өөрөөр хэлбэл, албан тушаалтан нь иргэнийхээ хувьд Үндсэн хуульд заасан эрхээ тэгш, ялгаварлан гадуурхагдалгүйгээр эдлэх боловч, албан тушаалтныхаа хувьд эдлэх тусгай эрх, үүрэг, хариуцлага, үүн дотор эрүүгийн хариуцлага нь албан тушаалынх нь онцлогоос шалтгаалан харилцан адилгүй байж болно гэж үзэж байна.

Иймд энэхүү үндэслэлээр Эрүүгийн хуулийн 294 дүгээр зүйл бүхэлдээ Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийг тус тус зөрчөөгүй гэж үзэж байна." гэжээ.

### **ҮНДЭСЛЭЛ:**

1. Эрүүгийн хуульд цэргийн албаны эсрэг гэмт хэргийг субъектын болон объектын тусгай шинжийг нь харгалзан бие даасан хэсэг болгон зохицуулсан байна.

2. Цэргийн албаны эсрэг гэмт хэргийн тусгай субъектын нэг болох захирагчийн нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцож, түүнд оногдуулах ялыг ялгамжтай тогтоосон нь хууль тогтоогчийн бүрэн эрхэд хамаарч байна.



Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС  
ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:**

1. Эрүүгийн хуулийн 294 дүгээр зүйлийн 294.1 дэх хэсэгт “Захирагч эрх мэдэл албан тушаалынхаа байдлыг урвуулсан, хэтрүүлсэн, албаны бүрэн эрхээ хэрэгжүүлээгүйгээс үлэмж хэмжээний хохирол учирсан бол гурваас дээш зургаан сарын хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”, мөн зүйлийн 294.2 дахь хэсэгт “Энэ хэргийн улмаас их буюу онц их хэмжээний хохирол, хүнд хор уршиг учирсан бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэж тус тус заасан нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг...нийгмийн... байдал, ...эрхэлсэн ажил, албан тушаал ...боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно...” гэснийг зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**ДАРГАЛАГЧ**

**Н.ЖАНЦАН**

**ГИШҮҮД**

**Ж.БОЛДБААТАР**

**Д.НАРАНЧИМЭГ**

**Ц.САРАНТУЯА**

**Д.МӨНХГЭРЭЛ**

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.

Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: [tugiin\\_medecelel@parliament.mn](mailto:tugiin_medecelel@parliament.mn)

Утас: 262420, 329612

Хэвлэлийн хуудас: 1.25

Индекс: 14003